

**“Стандарт ноос” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2018 оны хурлын тэмдэглэл**

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2018 оны 4 дүгээр сар 10-ны өдөр “Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын танхимд 15.00 цагаас эхлэв.

Хурлын ирцийг компанийн ТУЗ-ийн 2018.02.05-ны өдрийн 02\2018 тоот тогтоолоор томилогдсон тооллогын комиссын гишүүн Б.Даваажав, Б.Нандиг-Эрдэнэ, Х.Жанерке нар бүртгэж ирц бүртгэлийн тухай тооллогын комиссын тогтоол 01-ийг танилцуулав. Үүнд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчийн тоо 3, ирц 209339 ширхэг хувьцаа буюу 68,58% болж, Компанийн тухай хуулийн 63.5., болон Компанийн дүрмийн дагуу хурлын ирц хангалттай гэж үзэв. Хуралд компанийн ТУЗ-ийн дарга Ц.Зоригт, гишүүн Ё.Энхтөр, Баясгалан, Батцэцэг нар оролцов.

Л.Цэвээнравдан : Өнөөдрийн хуралд “Арилжаа импекс” ХК буюу Стандарт ноос ХК-ийн 3 хувьцаа эзэмшигч оролцож байгаа боловч хувьцааны тооны хувьд 68,58 хувьд хүрсэн байгаа нь хурал хүчин төгөлдөр болно. Компанийн ТУЗ-ийн 2018,02,05-ны өдрийн хурлаар хурлын даргаар намайг томилсон тул хурлын ажиллагааг нээж байна. Хурлын тэргүүлэгчдийг хэн хэнээр сонгох вэ, саналаа хэлнэ үү
Ц.Зоригт: Цөөхөн хувьцаа эзэмшигч байгаа тул 3 биш 1 хүнээр буюу хурлын даргаар томилогдсон Цэвээнравданг сонгох санал байна.

Бүгд зөвшөөрч гар өргөж батлав.

Л.Цэвээнравдан : Та бүхэнд хурлын материал тараагдсан, түүний дагуу хурлаа явуулья. Эхлээд хурлын хэлэлцэх асуудал, хурлын дэгийг батлуулья. Энэ хурлаар

- “Стандарт ноос” ХК-ийн 2017 оны ерөнхий байдал, 2018 оны үндсэн зорилтын тухай.

- “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлангийн тухай

- “Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн ээлжит сонгууль зэрэг үндсэн 3 асуудал хэлэлцэхээр ТУЗ-өөс тогтоосон. Материалд тусгагдсан дагуу хурлын хэлэлцэх асуудал, дэгийг батлахыг санал болгож байна, Хурлын дэгээр хурлыг 15,00 цагт эхэлж 17 цагт дуусгахаар төлөвлөж байна. дэмжиж байгаа бол гараа өргөнө үү.

Бүгд зөвшөөрч гар өргөн батлав.

Л.Цэвээнравдан : хэлэлцэх асуудлын дагуу 1-р асуудалдаа шууд орж, ТУЗ-ын дарга Ц.Зоригт илтлэл тавихыг урив.

Ц.Зоригт : Баянхонгор аймгийн “Стандарт ноос” ХК нь өмч хувьчлалаас өмнө аймгийн материал-техник хангамжийн бааз байсан бөгөөд МУ-ын Өмч хувьчлалын хуулийн дагуу 305248 ширхэг хувьцаатай нээлттэй ХК болж, хувьцаа нь 18 аймгийн нийт 5000 гаруй хувьцаа эзэмшигчдэд арилжигдсан, Монголын Хөрөнгийн Биржийн 2017.01.01- 2018.02.26-ны өдрийг дуустал хийгдсэн үнэт цаасны арилжааны мэдээгээр “Стандарт ноос” ХК нь 500 төгрөгийн хаалтын ханштай, 152,6 сая төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй байна.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдөр буюу 2-р сарын 26-ний өдрийн байдлаар хот, хөдөөгийн үнэт цаасны 38 брокер-дилерийн компанийн харилцагч болох 540 хүн тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд үүнээс өнгөрсөн онд нийтдээ 35 удаагийн арилжаагаар 4866 ширхэг хувьцаа зарагдаж, хаалтын ханш 500 төгрөг байна. Хэдийгээр Стандарт ноос ХК нь өнгөрсөн жилүүдэд МХБ дээрхи үнэт цаасны арилжаа нь сэргээгдэж өдөр тутмын арилжаанд хувьцаа нь орж байгаа боловч төсөл хөтөлбөрийн санхүүжилт байхгүй байгаагаас бие даасан үйл ажиллагаагаа эхлүүлж чадаагүй өдий хүргэлээ.

Харин тус компанийн томоохон хувьцаа эзэмшигч болох “Улаанбаатар хивс” компанийн хувьд хэдийгээр өөрийн хөрөнгө, хүч чадал, боломжийн хувьд хангалттай сайн биш байгаа боловч орон нутаг

дахь ноосны үйлдвэрийн ажилд багагүй анхаарал тавьж, өнгөрсөн 4 жилд нийтдээ 296,4 сая төгрөгийн урьдчилсан санхүүжилт хийж, төсөл хөтөлбөрийн зарим ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал, ноосны үйлдвэрийн зарим тоног төхөөрөмжийг худалдан авахад 142,4 сая төгрөг, үйлдвэрийн барилгын засвар, өргөтгөл, материалд 90,9 сая төгрөг, тоног төхөөрөмжийн суурилуулалтын зардалд 25 сая төгрөг, тээврийн зардалд 20,2 сая төгрөг, цалин хөлс, бусад зардалд 17,9 сая төгрөг тус тус зарцуулаад байна. Үүнээс зөвхөн 2017 онд Улаанбаатар хивс ХК-ийн зүгээс 133,9 сая төгрөг гаргаж, компанийн контор, үйлдвэрийн байрны дотоод засвар, дээврийн засваруудыг дуусгаж, 20 цонх шинэчлэн сольж, компанийн 147 м. блокон хашаа барьж, 40 тн.-ын том пүүг шинээр суурилуулж, худгийг ухан цэвэрлэж, гараж засварлаж, хуучин модон агуулахын суурь, тулгуур рамнуудыг шинэчлэв. Мөн орон нутгаас 122 тн. хонины ноос бэлтгэж, анхан шатны ялгалт хийж угаалгаж, цаашид хивсний үйлдвэрийн хэрэгцээнд ашиглахад бэлэн болгосон.

2018 онд "Стандарт ноос" ХК-ийн хувьд үндсэндээ ноосны үйлдвэрийг ажиллуулах зорилт тавин дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд : Үйлдвэрийн уурын зуух, тунгаагууыг тавьж ажилд оруулах, ноос угаах тоног төхөөрөмжүүдийг гүйцээж суурилуулах, зарим хуучин байр, зам талбай, агуулахыг засварлах, шинээр барих зэргээр 1-2 ноосны агуулахуудыг ашиглалтанд оруулж, уур, ус, цахилгаан, дулааны ажлуудыг гүйцээж үйлдвэрийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавьж байна. Үүний тулд төсөл, хөтөлбөрийн санхүүжилт олоход анхаарч хот, орон нутаг, төр засгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллахад анхаарч ажиллах болно.

Ё.Энхтөр : "Арилжаа импекс" ХК нь өнгөрсөн жилээс нэрээ өөрчилж Стандарт ноос ХК болсон. Компани сүүлийн 4 жил үндсэндээ үйл ажиллагаа явуулаагүй. Энэ компани маань үйл ажиллагаа нь зогсоод 18 жил болсон учраас хуучин чиглэлээрээ ажиллаж чадахгүй болсон, харин шинээр хувьцаа эзэмшигч Улаанбаатар хивс ХК хөрөнгө оруулалт хийж компанийг ноос ноолуур боловсруулах чиглэлээр шинэ чиглэлээр ажиллуулахаар зорьж байгаа боловч сүүлийн жилүүдийн эдийн засгийн хямрал, инфляци, тогтвортой бус бодлогын үүднээс төсөл хөтөлбөр хэрэгжиж чадаагүй байж байна.

Л.Цэвээнравдан : Компанийн санхүүгийн тайлан балансын хувьд үйл ажиллагаа явуулаагүй тул албан ёсоор гаргаагүй боловч "Улаанбаатар хивс" ХК-ийн зүгээс өөрийн оруулсан хөрөнгө оруулалт, хийсэн ажлуудын зардлуудаа нэгтгэн үзүүлсэн баланс юм. Нийтдээ 297 сая орчим төгрөгийн урьдчилсан зардал гарч ноосны үйлдвэрийг ажилд оруулахад чиглэгдсэн багагүй ажил хийгдсэн байдлыг үзүүлсэн. Цаашдаа үйл ажиллагаа эхлүүлбэл 2 компанийн хоорондын өглөг авлага болж шийдэгдэнэ. Энэ талаар асуух зүйл байна уу.

Асуулт гарсангүй тул 2-р асуудлыг хаав.

Л.Цэвээнравдан : Одоо 3 дахь асуудал бол компанийн ТУЗ-ийн 9 гишүүнийг сонгох асуудал бий, хурлын материалд ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдийн танилцуулга байгаа. Гол хөрөнгө оруулагч болох Улаанбаатар хивс ХК-ийн зүгээс 2 хүнийг шинээр оруулах санал өгсөн. Тухайлбал, үйлдвэрийн ерөнхий инженер Оюун-Эрдэнэ, цахилгааны инженер Батболд нарыг дэвшүүлсэн. Эд нар бол цаашид Стандарт ноос компанийн үйл ажиллагаатай шүүд холбогдож ажиллах чухал мэргэжлийн хүмүүс тул дэвшүүлсэн гэж үзсэн байна. Бусад гишүүд нь хуучин ТУЗ-ийн гишүүд байгаа. Саналын хуудасны асуулгуудыг хэрхэн бөглөх талаар, кумулятив аргын тооцооны талаар тайлбарлаад асуулт хариулт эхлүүлэв.

Асуулт-хариулт :

А.Чүлүүн : Би нилээн дээр үеээс танай хувьцаа эзэмшиж байгаа яагаад ногдол ашиг өгдөггүй юм бэ?

Ё.Энхтөр : Энэ компани маань үйл ажиллагаа нь өмч хувьчлалаас хойш зогсоод 18 жил болсон. Хуучин аймгийн материал техникийн хангамжийн бааз байж байгаад хуучин чиглэлээрээ ажиллаж чадахгүй болсон, тэгээд ч он удаан жил эзэнгүйрч зогсож байсныг нь Улаанбаатар хивс ХК хөрөнгө оруулалт хийж компанийг ноос ноолуур боловсруулах шинэ чиглэлээр ажиллуулахаар зорьж байгаа. Нэгэнт үйл ажиллагаа явуулахгүй зогсож байгаа тул ногдол ашиг хуваарилах асуудал ярих боломжгүй юм.

Б.Ганболд : Ер нь хэр их хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа вэ?

Ц.Зоригт: Анхны төсөл төлөвлөгөөгөөр бол 500 орчим сая төгрөгийн төсөл хөтөлбөр байсан, манай УБ хивс компани өнгөрсөн 3-4 жилд бараг 300 сая төгрөг гаргаж нилээд ажлыг нь нугаллаа. Энэ жил боломж гарвал дуусгах санаатай байгаа. Ингээд УБ хивс компани өөрөөсөө мөнгө гаргаад байгаа нь хүндрэлтэй байна. Цаашид санхүүгийн шинэ хямд эх үүсвэр олж байж төсөл хөтөлбөрөө дуусгах, өр төлбөрөө барагдуулах, эргэлтийн мөнгөтэй болох, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн бие дааж ажиллах, орон нутагт ажиллах, амьдрах мэргэжилтэй боловсон хүчинтэй болох гээд санаа зовоох асуудлууд их бий. Хотоос ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрүүдийг гаргаж байгаа ЗГ-ын бодлогод бидний хөрөнгө оруулалт таарч байгаа 1 талдаа сайн үйл боллоо.

Л.Цэвээнравдан : Өөр асуулт, санал хэлэх хүн байна уу?

Санал хэлэх хүн гарсангүй.

Л.Цэвээнравдан : Асуулт-хариултаа дууслаа гэж үзээд тооллогын комиссын дүнг сонсоё.

Б.Даваажав : Санал хураалтаар нийт 3 саналын хуудас тоологдсон, үүнээс хүчинтэй хуудас 3 хүчингүй болсон хуудас байхгүй. Тооллогын комиссын "Санал хураалтын үр дүнгийн тухай 2-р тогтоол, ТУЗ-ийн ердийн гишүүдийн санал хураалтын үр дүнгийн тухай 3-р тогтоол, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн санал хураалтын үр дүнгийн тухай 4-р тогтоолуудыг тус тус хавсралт дүнгийн хүснэгтийн хамт угшин танилцуулж, ирцийн бүртгэл, саналын хуудас, тооллогын комиссын тогтоолуудыг хурлын тэргүүлэгчид гардуулав.

Л. Цэвээнравдан : Санал хураалтын үр дүн, тогтоолууд нь зохих журмын дагуу гарсантай үялдуулан хурлаас гарах шийдвэрийн тогтоолын төслийг танилцуулья. Хурлын 1-р тогтоол буюу компанийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай тогтоолын төслийг нийтэд уншин танилцуулж санал хураав.

Санал хураалтаар 100% тогтоолын төслийг дэмжиж батлав.

Л. Цэвээнравдан : Стандарт ноос ХК-ийн ТУЗ-ийн ердийн 6 гишүүнийг батлах тухай 2-р тогтоолын төслийг танилцуулж, ТУЗ-ийн ердийн гишүүнд зохих санал авсан Б.Батболд, Б.Баясгалан, Ц.Зоригт, Л.Цэвээнравдан, З.Эрдэнээ, Ё.Энхтөр нарын нэрийг оруулж тогтоолын төслийг танилцуулав.

Санал хураалтаар 100% тогтоолын төслийг дэмжиж 2-р тогтоол батлагдав.

Л. Цэвээнравдан : Стандарт ноос ХК-ийн ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнд холбогдох санал авсан Л.Итгэлт, Г.Оюун-Эрдэнэ, Б.Уранбилэг нарын нэрийг атлах тухай 3-р тогтоолын төслийг танилцуулж санал хураав. Санал хураалтаар 100% тогтоолын төслийг дэмжиж ТУЗ-ийн хараат ус гишүүдийг батлах тухай 3-р тогтоолыг батлав.

Л. Цэвээнравдан : Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал 3 тогтоол гаргаж, хэлэлцэх асуудлуудаа шийдвэрлэлээ. Цаашид шинээр томилогдсон ТУЗ хурлаа хийж, ТУЗ-ийн дарга, нарийн бичиг, гүйцэтгэх захирлаа томилох болно. Хуралд идэвхитэй оролцсон та бүхэнд талархал илэрхийлж энэ хурлаа хааж байна. Бүгдэд амжилт хүе.

Хурал 16.30-д дуусав.

Хурлын протокол хянасан :

Л.Цэвээнравдан

Хурлын протокол хөтөлсөн:

Б.Даваажав.

2018 оны 4 дүгээр сар 10.